



ИНТЕРНЭТ БАНК ГАРЫН АВЛАГА

АГУУЛГА

1.ШИНЭ БОЛОМЖУУД

2.H3BTP3X

3.ҮНДСЭН НҮҮР

4.ГҮЙЛГЭЭ

- 4.1 Өөрийн данс хооронд
- 4.2 Голомтын данс хооронд
- 4.3 Банк хооронд
- 4.4 Гадаад гүйлгээ
- 4.5 Захиалгат шилжүүлэг
- 4.6 Гүйлгээний лавлагаа
- 4.7 Дансны дэвтэр

5.ТӨЛБӨР

- 5.1 Хэрэглээний төлбөр
- 5.2 Нэгж, Дата авах
- 5.3 Гаалийн төлбөр төлөх
- 5.4 Татвар төлөх
- 5.5 Торгууль төлөх
- 5.6 Ebarimt авто бүртгэл

6.ХАРИЛЦАХ ДАНС

- 6.1 Үлдэгдэл хуулга
- 6.2 Дансны эрхийн тохиргоо шинэ боломж
- 6.3 Харилцах данс хаах шинэ боломж
- 6.4 Харилцах данс нээх
- 6.5 Easy info бүртгүүлэх, сунгах

7.ХАДГАЛАМЖ

- 7.1 Үлдэгдэл хуулга
- 7.2 Хадгаламж нээх
 - 7.2.1. Хуримтлалын Хадгаламж нээх
 - 7.2.2. Хугацаагүй Хадгаламж нээх
 - 7.2.3. Хугацаатай Хадгаламж нээх
- Хадгаламж хаах шинэ боломж 7.3
- 7.4 Хадгаламж сунгах шинэ боломж

8.KAPT

- 8.1 Кредит болон Дебит карт
- Дебит карт захиалах шинэ боломж 8.2
- 8.3 Пин код авах шинэ боломж
- Дебит карт сунгах шинэ боломж 8.4
- Кредит картын төлбөр төлөх 8.5
- 8.6 Дебит карт нөхөн авах шинэ боломж

9.3ЭЭЛ

- 9.1 Зээлийн данс
- 9.2 Зээлийн төлбөр төлөх
- Хадгаламж барьцаалсан зээл 9.3
- 9.4 Зээл хаах
- 9.5 Дижитал зээл шинэ боломж
- 9.6 Зээлийн график шинэ боломж

10.МИНИЙ САНХҮҮ

- 10.1 Дашбоард шинэ боломж
- 10.2 Төсвийн жагсаалт
- 10.3 Гүйлгээний жагсаалт
- 10.4 Ангиллын жагсаалт
- 10.5 Гүйлгээний дүрэм^{шинэ боломж}

11.ОНЛАЙН ТОДОРХОЙЛОЛТ ШИНЭ БОЛОМЖ

12.ХУВИЙН ТОХИРГОО

- 12.1 Хувийн мэдээлэл шинэчлэх
- 12.2 Нууц үг солих
- 12.3 Нэвтрэх нэр солих

1. Шинэ боломжууд







2. Нэвтрэх



Ханшийн самбар, АТМ Салбар байршил, Тооцоолуур

ENG 🗸			?	
	Сайн сайхныг санхууж	нк		
	Нэвтрэх нэр: Amaraaa123			
	Нууц үг	мартсан?		
	нэвтрэх			
	БҮРТГҮҮЛЭХ			
	© Golomt Bank, All rights reserv	ed		

Англи, Хятад, Монгол хэл сонгох

ENG		?
	Сайн сайхныг санхунжуулнэ	
	Нэвтрэх нэр: Amaraaa123	_
	Нууц үг	ан?
	НЭВТРЭХ	
	БҮРТГҮҮЛЭХ	
•	© Golomt Bank, All rights reserved	

Бүртгүүлэх

"Бүртгүүлэх" товч дээр дарж банкны салбарт ирэлгүй Интернэт банкны үйлчилгээнд шинээр бүртгүүлэх боломжтой.

Нэвтрэх нэр

Интернэт банк үйлчилгээнд бүртгүүлэхэд банкнаас танд олгосон **НЭВТРЭХ НЭР** болон **НЭВТРЭХ НУУЦ ҮГИЙГ** бичиж оруулан нэвтэрнэ.

Э-Токен

Харин э-токен төхөөрөмжтэй хэрэглэгчдийн хувьд "Нэвтрэх" товч дарсны дараа э-токений 6 оронтой дугаарыг оруулсны дараа нэвтэрнэ.

Нууц үг

Шинэ хэрэглэгч болон нууц үг дахин авсны дараа нэвтэрч байгаа тохиолдолд **НЭВТРЭХ нууц үг** болон **БАТЛАХ нууц үгийг** (буюу гүйлгээний нууц үг) шинэчлэх нүүр гарч ирэх бөгөөд заавал шинэчилсний дараа интернэт банкны үйлчилгээнд нэвтрэх болно.

САНАМЖ

- Нэвтрэх нууц үгээ 5-н удаа буруу оруулбал, таны нууц үг блоклогдоно.
- Хэрэв таны нууц үг блоклогдсон бол та 1800-1646 лавлах төвд бүртгэлтэй утасны дугаараас хандах эсвэл салбар нэгжид хандан нууц үгийн блокыг гаргуулах боломжтой.
- Хэрэв та НЭВТРЭХ нууц үг болон БАТЛАХ нууц үгээ мартсан бол нэвтрэх хуудсанд байрлах "мартсан?" товч дээр дарна уу. Мөн 1800-1646 лавлах төвд бүртгэлтэй утасны дугаараас хандан нэвтрэх нууц үг авах боломжтой.

3. Үндсэн нүүр

Нэвтрэх нэр, нууц үгээ оруулан нэвтрэн орсны дараа үндсэн нүүр дараах байдлаар харагдана.





Цалингийн 3.800.000∓ Картын хари 400,000₮ Энгийн хари 123.000₮ 610,000₮ ХАДГАЛАМЖИЙН ДАНО 110,000₮ Хугацаатай хадгаламж 1.112.000₮

Дэд цэс

дор харуулна.

Танд шаардлагатай бүх

дансны жагсаалтыг нэг

Түргэн холбоос нь харилцагчийн тухайн өдөр хийх хамгийн өндөр магадлалтай гүйлгээг харуулна.



Үндсэн цэсний баруун дээд буланд дараах 3 цэс байрлана:







Тусламж цэс

Онлайн зөвлөх, чатбот, 1800-1646 лавлах мөн интернэт банкны нэгдсэн заавар байршина.

Сонордуулга цэс

Сонордуулга цэс нь таны Картын, Хадгаламжийн болон Нууц үг дуусах хугацаа зэрэг хэрэгцээт мэдээллүүдийг харуулна.

Хувийн тохиргоо цэс

Хувийн тохиргоо цэсийг ашиглан та хувийн мэдээлэл өөрчлөх, нэвтрэх нэр шинэчлэх, нууц үг солих болон интернэт банкны холболтоос гарах боломжтой.

Миний санхүү дашбоард

Таны тухайн сарын нийт орлого, зарлагын дүн болон зарцуулалтын мэдээллийг харуулна.



Таны бүхий л бүртгэлтэй хэрэглээний төлбөрийн мэдээллийг харуулна.

Дижитал чалленж баннер

Даалгавар биелүүлж, тодорхой хугацаанд зарлагдах урамшуулалт аяны тухай мэдээллийг авах боломжтой.

Бүтээгдэхүүн санал болгох хэсэг

Харилцагч таны хэрэгцээнд тохирох хамгийн оновчтой бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох бөгөөд та тухайн баннер дээр дарж дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.



Түгээмэл ашиглагддаг валютуудын тухайн өдрийн бэлэн бус ханшийн мэдээллийг харуулна.





Па	Ma	Πv		59	Fa	Н
да 29	30	31	01	02	03	0
05	06	07	08	09	10	1
12	13	14	15	16	17	18
19	20	21	22	23	24	2
26	27	28	29	30	31	0
15	3ээл	іийн эр	гэн төл	өлт		

Валю	т	Авах	Зарах
\$	USD	2,647.0	2,647.0
Ť	АНУын доллар	2.00 ^	3.00 ~
-	EUR	2,953.0	2,961.0
Ċ	Евро	2.00 ^	2.00 ~
×	CNY	381.50	382.20
Ċ	БНХАУ-ын юань	2.00 ^	3.00 ~
	RUB	41.30	41.70
	ОХУ-ын рубль	0.20 ^	

4. Гүйлгээ

4.1 ӨӨРИЙН ДАНС ХООРОНД ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Гүйлгээ үндсэн цэсний "Өөрийн данс хооронд" дэд цэсийг сонгох ба дараах дэлгэц харагдана.

Gr	ОПОМТ БАНК Сайн сайлныг самлуулуулаг	Харилцагчийн дугаар	Өглөөний мэнд 💥 Баармагнай! Сурад шисчилсээ: 2019.04.20 10 30МИ 🔗 🙀 ММТ 🗸
A	нүүр	гүйлгээний төрөл	🔞 гийлгээ • өөрийндансхооронд
+*	гүйлгээ Өөрийн агж хоорона	• • •	Ø Ø
	Голомт хооронд гүйлгээ Банк хооронд	Өөрийн данс хооронд Голомтын данс хооронд	Гүйлгээ Баталгаажуулах Амжилттай
	Гадаад шилжүүлэг Нийт гүйлгээ	<u>ش</u> • ۰ •	илгээгч 🥑 Дансны дугаар Сугар (MNT)
	гүйлгээний лавлагаа Захиалгат шилжүүлэг Кредит картын төлбөр Зоолийн төлбөр	Банк хооронд Гадаад гүйлгээ	хүлээн авагч 🥑 Өөрийн данс Сонгох 🗸
•	Дансны дэвтэр	БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ	
	ХАРИЛЦАХ ДАНС	 Гүйлгээний лавлагаа 	гүйлгээний мэдээлэл О Гүйлгээний дүн 0.0 млт ч
* =	хадгаламж Карт	• Захиалгат шилжүүлэг	О Гүйлгээний утга: Заавал биш
ŝ	333 7	• Кредит картын төлбөр	
	нэмэлт үйлчилгээ	• Зазличин теловр	
îĭí ♥	ХАНШИЙН САМБАР БАЙРШИЛ		үргэлжлүүлэх
	тооцсолуур		

Та Гүйлгээ хийхдээ Илгээгч, Хүлээн авагч болон Гүйлгээний мэдээлэл талбаруудын мэдээллийг бүрэн гүйцэд бичиж оруулан, "Үргэлжлүүлэх" товч дарснаар Баталгаажуулах нүүр гарч ирэх бөгөөд мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулснаар таны гүйлгээ хийгдэж Дуусгах нүүр гарч ирнэ.

Хэрэв та тухайн гүйлгээг сар бүр автоматаар хийдэг болгохыг хүсвэл Захиалгат шилжүүлэг үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой.



Өөрийн данс хоорондын гүйлгээ нь өдрийн гүйлгээний хязгаарлалтгүй болно. >

4.2 ГОЛОМТЫН ДАНС ХООРОНД ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Гүйлгээ үндсэн цэсний "Голомтын данс хооронд" дэд цэсийг ашиглан өөрийн данснаас Голомт банк дахь дурын данс руу гүйлгээ хийх боломжтой.



Та Гүйлгээ хийхдээ Илгээгч, Хүлээн авагч болон Гүйлгээний мэдээлэл талбаруудын мэдээллийг бүрэн гүйцэд бичиж оруулан, "Үргэлжлүүлэх" товч дарснаар Баталгаажуулах нүүр гарч ирэх бөгөөд мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган, Батлах нууц үгээ (буюу гүйлгээний нууц үг) оруулснаар таны гүйлгээ хийгдэж Дуусгах нүүр гарч ирнэ.

Хэрэв та тухайн гүйлгээг сар бүр автоматаар хийдэг болгохыг хүсвэл Захиалгат шилжүүлэг үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой.

САНАМЖ

- >
- >
- > уу.

			Өглөөний мэнд 💥 Суулд шаначалсан: 2019.0	Баярмагнай! 04.20 10:30AM	(P) (MNT ~
ПОМТЫН ДАНС ХООРОНД					
	Гүйлгээ		 Баталгаажуулах Амжилт 	тай	
илгээг	•	Шилжүүлэх данс сонгох Мягмардорж (MNT) - 	Боломжит үлдэгдэл: 27,138.4ξ	5 MNT	
хүлээнаваг ийн дансны г оруулахад цигчийн нэр бөглөглөнө	0	Дансны дугаар (Заавал) Хүлээн авагчийн нэр (Заавал)		■ Дан хадг аваг энд	сны дэвтэрт алсан хүлээн чийг сонгох бол дарна уу.
гүйлгээниі мэдээлэл	0	Гүйлгээний дүм 27,138,45	USD Шилжүүлэх дүн: 27,138.44 Хүлээн авах дүн: 27,138.41	5 MNT	
	0	Гүйлгээний утга: Заавал биш	1.0 — 2005.X Үргэлжлүүлэх		

Кредит картнаасаа бусад данс руу бэлэн бус шилжүүлэг хийх боломжгүй.

Шилжүүлэг хийх үед хүлээн авагчийн данс дээр картын дугаар бичих боломжгүй.

Интернэт банкны өдрийн гүйлгээний лимит нь 20-500 сая төгрөг хүртэл байдаг бөгөөд 50 сая төгрөгөөс дээш дүнгээр гүйлгээ хийх бол э-токен төхөөрөмж ашиглах шаардлагатай. Гүйлгээний лимитийг нэмэгдүүлэх бол салбарт хандана

4.3 БАНК ХООРОНД ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Энэхүү цэсийг ашиглан өөрийн данснаасаа бусад банкны дурын данс руу гүйлгээ хийх боломжтой.



Та Гүйлгээ хийхдээ Илгээгч, Хүлээн авагч болон Гүйлгээний мэдээлэл талбаруудын мэдээллийг бүрэн гүйцэд бичиж оруулан, "Үргэлжлүүлэх" товч дарснаар Баталгаажуулах нуур гарч ирэх бөгөөд мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулснаар таны гүйлгээ хийгдэж Дуусгах нүүр гарч ирнэ.



САНАМЖ

- > гүйлгээ тогтмол буюу 24/7 цагаар хийгдэнэ.
- >
- уу.

Жич: Дансны дэвтэр дээр дарах үед дараах 2 сонголт гарч ирнэ:

- 1. Голомтын дансны дэвтэр гэдэг нь Дансны дэвтэрт хадгалсан дансны мэдээлэл
- 2. Монгол банкны дансны дэвтэр гэдэг нь Хүлээн авагчийн Монгол банкны дансны дэвтэрт бүртгэгдсэн гар утас, гэрийн утас эсвэл и-мэйл хаяг

Банк хоорондын төгрөгийн бага дүнтэй (3 сая төгрөг болон түүнээс доош дүнтэй)

> Банк хоорондын төгрөгийн их дүнтэй (3 сая төгрөгөөс дээш дүнтэй) гүйлгээ ажлын өдрүүдэд 9:00-16:00 цагийн хооронд хийгдэнэ. Тухайн ажлын өдрийн 16:00 цагаас хойш шилжүүлсэн гүйлгээ дараагийн ажлын өдрийн 09:00-11:00 цагийн хооронд шилжүүлэгдхийг анхаарна уу.

Банк хоорондын валютын гүйлгээ шилжүүлгийн дүнгээс үл хамааран ажлын өдрүүдэд 9:00-17:30 цагийн хооронд хийгдэнэ. Ажлын бус цаг болон амралтын өдрүүдэд хийгдсэн гүйлгээ дараагийн ажлын өдрийн 09:00-11:00 цагийн хооронд шилжүүлэгдхийг анхаарна уу.

> Интернэт банкны өдрийн гүйлгээний лимит нь 20-500 сая төгрөг хүртэл байдаг бөгөөд 50 сая төгрөгөөс дээш дүнгээр гүйлгээ хийх бол э-токен төхөөрөмж ашиглах шаардлагатай. Гүйлгээний лимитийг нэмэгдүүлэх бол салбарт хандана

4.4 ГАДААД ГҮЙЛГЭЭ ХИЙХ

Уг цэсийг ашиглан өөрийн данснаасаа гадаадын банкууд дахь данс руу SWIFT сүлжээгээр дамжуулан гуйвуулга илгээх боломжтой.

Сайс сайона самаряерно	Эглеений изна ¥ Бакрмагнай! Суудшиеениесы 2019.04.20 10.90.0.М
нур гүйлгээний төрөл	C PYURES • FADAAQUURKYYASF
с→ гүйлгээ Онрийн данс хооронд	Ø Ø
Голомт хооронд гүйлгээ Банк хооронд Банк хооронд	Гүйлгээ Баталгаажуулах Амжилттай
Гадала цигуруулаг Цай Нийг гүйстээ Гүйлтээний лашгагаа	шилжүүлэх 🕐 Шылжүүлэх данс сонгох данс Мягмардорж (MNT) - Боломжит үлдэгдэл: 27,138.45 миг
Захнангат шилжүүлэг Кродит хартан талбар Зээлийн талбар Зээлийн талбар	хүлээн Авах 🔮 бусад Валют рубль () Гүйн ээ хийх валог рубь бол хириллээд, данс бусад валогын хөддэлэлийг англир бинж шаардлагатайг акоарна уу.
Дансны дэвтэр Бусад үйлчилгээ • минжи смжүү • Гүйлгээний лавлагаа	 Хулозна ваалчийся нарр (Зававал Биш) Завхаян Англиар Биннез уу.
 хлинцах данс хладгаламж Захиалгат шилжүүлэг 	⊘ Хулзэн авагчийн халт: (Заавал)
 кот Кредит картын төлбөр Зээл 	Alencea Jyraap: (3aaaan) SwiFT kog SwiFT kog
толбор 3ээлийн төлбөр Памоны павтар Памоны павтар	(3aasan) Xaikx
Ш ханшийн самбар Ф байшийл	гүйлгээний ороно Гүйлгээний дүн Мэдээлэл ОООО ММТ у
	О Гүйн зэний утга: (Заавал биш) ①
	О Зориулалт: Сонгох У
	Банкови бусад мадралал: Бичних (1)
	Одикккуллагч бенков шимттал талокс ☑ Хулазн авагч Шилжүүлэгч
	ХЭЛЦЭЛ ОРУУЛАХ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

Та Гүйлгээ хийхдээ Илгээгч, Хүлээн авагч болон Гүйлгээний мэдээлэл талбаруудын мэдээллийг бүрэн гүйцэд бичиж оруулан, "Үргэлжлүүлэх" товч дарснаар Баталгаажуулах нүүр гарч ирэх бөгөөд мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган, Батлах нууц үгээ (буюу гүйлгээний нууц үг) оруулснаар таны гүйлгээ хийгдэж Дуусгах нуур гарч ирнэ.

0	Дамжуулагч банкны шимтгэл төлөх:
	🗹 Хүлээн авагч 🗌 Шилжүүлэгч
\rightarrow	Загвар гүйлгээ ашиглах
	ХЭЛЦЭЛ ОРУУЛАХ

САНАМЖ

- болзошгүй тул та бүх талбаруудыг үнэн зөв, бүрэн бөглөнө үү.
- ойр байрлах салбар нэгжид хандан тусламж авах боломжтой.
- уу.

Хэрэв та тухайн гүйлгээний мэдээллийг хадгалж дараагийн удаа дахин ашиглахыг хүсвэл Загвар гүйлгээ ашиглах сонголтыг сонгоорой.

> Зарим улс руу гүйлгээ хийхэд өөр онцлогтой байдаг тул та Анхааруулгын тэмдгээр тэмдэглэсэн талбаруудын зөвлөмжтэй сайтар танилцаж бөглөнө үү.

> Голомт банк нь мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын байгууллагуудын гишүүн тул аливаа сэжигтэй гүйлгээ, хар жагсаалт дахь улсууд руу шилжүүлэх гүйлгээ, утга, зориулалт тодорхойгүй гүйлгээнүүдийг зогсоож

> Гадаад гүйлгээтэй холбоотой асуудал гарвал "Лавлах төв 1800-1646" болон өөрт

> Интернэт банкны өдрийн гүйлгээний лимит нь 20-500 сая төгрөг хүртэл байдаг бөгөөд 50 сая төгрөгөөс дээш дүнгээр гүйлгээ хийх бол э-токен төхөөрөмж ашиглах шаардлагатай. Гүйлгээний лимитийг нэмэгдүүлэх бол салбарт хандана

4.5 ЗАХИАЛГАТ ШИЛЖҮҮЛЭГ

Харилцагч та **Гүйлгээ** үндсэн цэсний **"Захиалгат шилжүүлэг"** дэд цэсээр дамжуулан сар бүр тогтмол дүнгээр өөрийн болон бусдын Голомт банкны данс руу автоматаар гүйлгээ хийгдэх үйлчилгээнд бүртгүүлэх боломжтой.

Хэрэв та өмнө нь уг үйлчилгээнд бүртгүүлж байсан бол мэдээлэл нь доор зурагт үзүүлснээр харагдана.



Холбогдох **Мэдээллүүдийг** бөглөн "Үргэлжлүүлэх" товч дарснаар **Баталгаажуулах** нүүр гарч ирэх бөгөөд мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган, Батлах нууц үгээ (буюу гүйлгээний нууц үг) оруулснаар таны хүсэлт илгээгдэж **Дуусгах** нүүр гарч ирнэ.

4.6 ГҮЙЛГЭЭНИЙ ЛАВЛАГАА

Харилцагч та Гүйлгээ үндсэн цэсний "Гүйлгээний лавлагаа" дэд цэсийн тусламжтайгаар өөрийн данснаас хийгдсэн бүх гүйлгээний дэлгэрэнгүй мэдээллийг шүүн харах боломжтой.



4.7 ДАНСНЫ ДЭВТЭР

Харилцагч та бүх төрлийн гүйлгээнд дансны дэвтэр ашиглан хурдан, хялбар аргаар гүйлгээ хийхийг хүсвэл **Гүйлгээ** үндсэн цэсний **"Дансны дэвтэр"** дэд цэсийг ашиглан дансны мэдээллээ бүртгүүлээрэй.

Дансны дэвтрийн жагсаалт:

Сайн сийхэнг синхүүхүүлээ		~ &		
нуур	гүйлгээний төрөл		🔇 гүйлгээ	• ДАНСНЫ ДЭВТЭР
≓ гүйлгээ ∨		S	Гүйлгээний төрө Бүгд	л
Өөрийн данс хооронд Голомтын данс хооронд	Өөрийн данс хооронд	Голомтын данс хооронд	Нар	Дансны дугааз
Банк хооронд Гадаад шилжүүлэг		6	Талман	
Гүйлгээний лавлагаа Захиалгат шилжүүлэг	Банк хооронд	Гадаад шилжүүлэг	Намуун	
Кредит картын төлбөр Зээлийн төлбөр	БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ			
Данснундэвтэр	 Гүйлгээний ла 	влагаа		
• миний санхуу >	• Захиалгат шил	пжүүлэг		
🖬 ХАРИЛЦАХ ДАНС 🗲 🗲	• Кредит карты	н төлбөр		
🗰 хадгаламж 💦 🔪	• Зээлийн төлбо	op		
КАРТ >	• Дансны дэвтэ	Р		
Этальар				

			Өглө Сүүлд	өний мэнд <u></u> Баярм шиначилсан: 2019.04.20 10	нагнай! 130AM	MNT ~
1Й ЛАВЛАГ	'AA					
		~	Шилжүүлсэн огноо 2019.06.09		Төгсгөл	-
илцах(MNT) ·		~	Шилжүүлсэн доод дүн 0.00	\rightarrow	Шилжүүлсэн дээд дүн 0.00	
нсны дугаар:			Гүйлгээний төлөв: Амжилттай	~	ХАЙХ	
Гүйлгээний огноо	Шилжүүлэгч	Хүлээн авагч	Нийт дүн	Гүйл ору	тээний мэдээ улан " Хайх "	эллээ товч
2019-06-11 20:12	Мягмардорж		4,500,000.00 MNT		дээр дарна у	у.
2019-06-11 20:12	Мягмардорж		4,500,000.00 MNT	Амжилтгүй	Баярлалаа андаа	:
2019-06-11 20:12	Мягмардорж		4,500,000.00 MNT	Амжилттай	Баярлалаа андаа	:
2019-06-11 20:12	Мягмардорж		4,500,000.00 MNT	Буцаагдсан	Баярлалаа андаа	:
2019-06-11	Мягмардорж		4,500,000.00 MNT	Амжилттай	Баярлалаа андаа	

			Өглөөнчий мэнд 🔺 XXXXX Сүүлд жалбогдсон : 2019.11.13 09:34	мон 🗸
Таны хадгал дэвтриі	ісан бүх Д йн жагсаал	ансны пт		+
Банк	Валют	Гүйлгээний төрөл		
Голомт банк	MNT	Голомтын данс хооронд	Γγίητας χωίας	:
Хаан банк	MNT	Банк хооронд	Гүйлтээ хийс	1
			Энд дарж дэвтрийн дэлгэрэн харах мөн дэвтрийг устгах б засах боломжтой.	ігүйг олон

Дансны дэвтэрт данс нэмэх:

Собе соблект санарумерно	Харынцагчейн дугаар	Sec. Control of Contro	леений мэнд 🗻 XXXXXX 🔔 🔕 МОН 🗸
 нтор гтйлгээ Өөрийн данс хооронд Голомтын данс хооронд 	гуйл заний төрөл С Формійн дажс хооронд	С ГҮЙЛГЭЭ • ДАНСНЫ ДЭВТЭР ҮҮСГЭХ С ГҮЙЛГЭЭ • ДАНСНЫ ДЭВТЭР ҮҮСГЭХ С Г ГҮЙЛГЭ • ДАНСНЫ ДЭВТЭР ҮҮСГЭХ С Г ГҮЙЛ • ДАНСНЫ ДЭВТЭР ҮҮСГЭХ С Г ГҮЙЛ • ДАНСНЫ ДЭВТЭР ҮН ГЭР ДЭР ДЭР ДЭР ДЭГЭ С Г ГҮЙЛ • ДАНСНЫ ДЭВТЭР ҮН ГЭР ДЭГЭ С Г Г ГҮЛ • ДАНСНЫ ДЭР ДЭР ДЭР ДЭР ДЭГЭ <th></th>	
Банк хооронд Гараад шилохуног Гүйгэсэний лаалагаа Захиалгат шилохуног Кродуг хартаа танбор Захайн танбор Дансы дэлгэр	Ф С Банк хооронд Гадаад шилжүүлэг Бискд үйлчилээ Гадаад • Гүйлтээний лавлагаа • Түйлтээний лавлагаа	Глійлгээний төнөл о Голонг бөж Бусад банк: динсны мадээлэл Тонч нар (Заавал) Дансон дугаар (Заавал)	Голомтын данс хоорон, эсвэл Бусад банк хооронд гэсэн төрлөөр дансны дэвтэ нэмэх боломжтой
меняяйскогуу харилцахданс харилцахданс харт харт	 Крадит картын төлбөр Заалийн төлбөр Дансы давтар 	(Завал) (Завал) БУЦАХ УРГЭЛЖЛҮҮЛЭХ	

5. Төлбөр

5.1 ХЭРЭГЛЭЭНИЙ ТӨЛБӨР

Энэхүү цэсийг ашиглан та интернэт, гар утас, цахилгаан, СӨХ болон бусад төлбөрөө төлөх боломжтой. Хэрэглээний төлбөр нь өдрийн гүйлгээний хязгаарлалтгүй болно.

Та уг цэсээр дамжуулан хийсэн бүх гүйлгээнийхээ мэдээллийг **Гүйлгээ** үндсэн цэсний **"Гүйлгээний лавлагаа"** дэд цэсээс харах боломжтой.

Төлбөр төлөх:



Байгууллага бүртгэх:

Хэрэв танд бүртгэгдсэн хэрэглээний төлбөр байхгүй бол "Байгууллага бүртгэх" товч дээр дарж бүртгэлийг хийнэ үү.

Собе соблека сокарукарова	Харилцагчейн дугаар	۲				Үдшийн мэнд 📩 ТЭЛМЭН БАЯНМ Сүүлд холбогдоон : 2019.11.13 02:16	өнх 🛆 🔕	мон ∨
🗙 нуур	Бусад үйлчилгээ	й телберүүд	Таны бүртгэсэн мэдээлэл "Бүртгэлтэй т	төлбөриин гөлбөрүүд"				
≓ гүйлгээ >	Хэрэглээний төлбөр	>	хэсэгт харагдана.	O				
🗳 миний санхүү 💙				уллага сонгох	Баталгаажуулах			
📼 ХАРИЛЦАХ ДАНС 🔰	Нэгж карт сунгах	>						
🛱 хадгаламж 🔰	🕒 Гаалийн төлбөр	>		Харилцаа холбоо				
🔳 карт 💦 🔶				МООИКОМ				
🛎 зээл 🔹 🗲 🕹								
🕫 төлбөр 🗸 🗸	🖻 Торгууль төлөх	>	0	0	Ο	0		
Хэрэглээний төлбөр	💩 E-barimt авто буртгал	>	Харилцаа холбоо	Интернэт кабел телевиз	СӨХ	Цахилгаан		
Нэгж карт сунгах								
Гаалийн төлбөр Татвар төлөх			0	8	0	0		
Торгууль телех			Дааттал	Агаарын тээврийн	Контор	Бусад		
E-barimt авто бүртгэл				үйлчилгээ				
🛢 нэмэлтүйлчилгээ >				_				
🗃 ханшийн самбар				YP	гэлжлүүлэх			
АТМ БАЙРШИЛ								
😸 тооцоолуур								
								B

5.2 НЭГЖ, ДАТА АВАХ

Төлбөр үндсэн цэсний **"Нэгж дата авах"** дэд цэсээр дамжуулан та өөрийн болон бусдын гар утсыг нэгжээр цэнэглэх боломжтой.



					Удшийн мэнд 🛓 ТЭЛМЭН БАЯНМӨНХ Сүүлд холбогдсон : 2019.11.13 02:20	٩	8	мс
	•	овах Баталга		🥑 Дуусгах				
		нэгж		ДАТА				
(ҮЛЭЭН АВАГЧ	0	Үүрэн холбооны оператор Сонгох			~			
	0	Нагж Сонгох			~			
	0	Цэнэглэх дугаар (Заавал)						
КҮҮЛЭГЧ ДАНС	0	Шилжүүлэгч данс			~			
				Боломжит үлдэгдэл: Хүлээн авах дүн Шилжүүлэх дүн	956.10 mnt 0.00 mnt 0.00 mnt			
		_						
		үргэлж	түүлэх					
								G

5.3 ГААЛИЙН ТӨЛБӨР ТӨЛӨХ

Та уг цэсийг ашиглан хүлээгдэж буй гаалийн төлбөрөө төлөх боломжтой. Гаалийн төлбөр нь өдрийн гүйлгээний хязгаарлалтгүй болно.



5.4 ТАТВАР ТӨЛӨХ

Та уг цэсийг ашиглан хүлээгдэж буй татварын төлбөрөө Татварын жагсаалтаас сонгон эсвэл Нэхэмжлэхийн дугаараар төлөх боломжтой. Татвар төлөлт нь өдрийн гүйлгээний хязгаарлалтгүй болно.



5.5 ТОРГУУЛЬ ТӨЛӨХ

Та Төлбөр үндсэн цэсний "Торгууль төлөх" дэд цэсээр дамжуулан өөрийн болон бусдын нэр дээрх торгуулийн төлбөрийг онлайнаар төлөх боломжтой.

Тээврийн хэрэгслийн улсын дугаар эсвэл Жолооны үнэмлэхийн дугаарын аль нэгийг оруулан "Хайх" товч дээр дарснаар торгуулийн мэдээлэл гарч ирнэ.

ЭЭ Бүх төлбөрүүд	« тельер • торгууль төлөх		
ний төлбөр > эт сунгах >	Талирийн харагсал Улсын дугаар	Жалооч	Санамск Таябар мийдсанээс хайш ахсныг 7 хээсгийн дотор зарчинйн мэдээллээс хасалт жийдээийг анхаарн Зарчинйн мэдээлэлтэй холбоотой асуудлаг хаагаар орж харна уу. Зарчинйн мэдээлэлтэй холбоотой асу Голомт банх харнуцаагүй.
nančap >	Бааввилстангляглада адансан Нагдугаада агнааглаад зодиссан СБД Улсани Ин Далгуур бадруунаас ауун 20,000.00 - MNT	<u>Tanax</u> 2019-10-17	Гүйлгээ хийхийн тулд тухайн торгуулийн харалдаа байрлах "Төлөх" товч дээр дарна уу. 2019-10-0
ыгдсан төлбөр > Айгууллага бүртгэх	5498UNC150005004043 Нагдитээр этнээтээр зорнсон Нарын Фүүдс баруунаас зүүн	Tanox 2019-09-05	54981.ИС100003004673 Нагдугар анаагар зорчсон ЧД 11-р сургууль зунаас баруун 20.000.00 А.М.Т. 2019-09-0
	20,000.00 - мінт 5498UNC190212007783 Нигдлээр элежэээр зорнсон Б3Д ХААЯам баруунаас зүүн	Tenex	5498UNC180423000031 Хурд хэгрүүлсэн ХУД 120-н мясат урдаас хойш
X حصاب المحمد ا	Бапагазакуунах Дууспах		
Данови дугаар Түйнгээлий дун 20000	Соловоог ундергаат: 956.10 мг МИТ Уласти и и 200000 гот		Гүйлгээ нүүрэн дэх талбаруудыг бөг "Үргэлжлүүлэх" т дарснаар Баталгаажуу нүүр гарч ирэх бөг мэдээллээ зөв оруул эсэхээ шалган Батлах н
ХҮЛЭЭН АВАГЧ Хүлээн авагчийн мэдээлэл Гүйлгээний утга	Хилээн авыс дүн 20,000.00 мет Шилээүүлэс дүн 20,000.00 мет УБ.ЗХУТ хүү торгуулийн орлого		нууц үг) оруулснаар та гүйлгээ хийгдэж Дуус нүүр гарч ирнэ.
	r сунтах antiop nax Toxx Toxx argent toxfoop argent toxfoop argent toxfoop argent toxfoop Tyfer and Tyfer	Youdaryarapa Youdaryarapa <td>repark who who who who who who who who who who</td>	repark who

САНАМЖ

- > Торгууль төлөлт нь өдрийн гүйлгээний хязгаарлалтгүй болно.
- Төлбөр хийгдсэнээс хойш ажлын 7 хоногийн дотор зөрчлийн мэдээллээс хасалт > хийгдэхийг анхаарна уу.
- Хайлтаар гарч ирж буй торгуулийн мэдээлэл нь Цагдаагийн Ерөнхий Газар > Мэдээллийн Технологи, Холбооны Төвийн мэдээллийн сангаас автоматаар татагдаж байдаг тул Зөрчлийн мэдээлэлтэй холбоотой асуудлыг https://torguuli.police.gov.mn/ хаягаар орж авна уу.
- Зөрчлийн мэдээлэлтэй холбоотой аливаа асуудлыг Голомт банк хариуцахгүй. >
- Банк хоорондын гүйлгээний шимтгэл ерөнхий нөхцөлийн дагуу тооцогдоно. > Шимтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.golomtbank.com хаягаар орж харна уу.

5.6 EBARIMT АВТО БҮРТГЭЛ

Та Ebarimt.mn дээр бүртгэлтэй утасны дугаараа оруулснаар автомат бүртгэлтэй байгууллагуудын НӨАТ-ын баримтыг автоматаар буртгэх болно.



6. Харилцах данс

6.1 ҮЛДЭГДЭЛ ХУУЛГА

Энд таны бүх харилцах данс хэрэглээний эрэмбээр харагдах бөгөөд та данс дээр дарж нэмэлт үйлчилгээнүүдийг авах боломжтой.



6.2 ДАНСНЫ ЭРХИЙН ТОХИРГОО

Энд таны өөрийн нэр дээрх болон хамтран эзэмшдэг данснуудын мэдээлэл харагдах бөгөөд та "Эрх нээх/хаах" хэсгийн товч дээр дарж аль данснаас гүйлгээ хийж байх мөн аль дансны мэдээллийг харж байх тохиргоог тохируулах боломжтой.

Сайн сайоныг санхуулуулао	Харилцагчийн дугаар	~ (3	2					Үдшийн мэнд 📩 ТЭЛМЭ Сүүлд холбогдсон : 2019.11.13 02	ныяныны 🕼 🔕
нүүр	ХАРИЛЦАХ ДАНС			ДАНСНЫ ЭРХИЙН ТОХИРГОО					
гүйлгээ >	тэлмэн	Үлдэгдэл	:	Дансны дугаар	Валют	Дансны товч нэр	Харах эрх	Гүйлгээний эрх	Эрх нээх/хаах
миний санхүү >							Тийм	Тийм	
харилцах данс 🗸 🗸	Норкутын данс	Үлдэгдэл	1				Тийм	Тийм	
Үлдэгдэл, хуулга Ланс нээх	тэлмэн	Ynnsenan					Тийм	Тийм	
цанс хаах	-	10017-0-001					Тийм	Тийм	
ансны эрхийн тохиргоо	+ 1946	2 H3 3 Y					Тийм	Тийм	
адгаламж >	Than						Тийм	Тийм	
арт >							Тийм	Тийм	
с пес							Тийм	Тийм	
өлбөр >							Тийм	Тийм	
аэмэлт үйлчилгээ >							Тийм	Тийм	

			Үдшийн м э Сүүлд холбо	энд 📥 ТЭЛМЭН эгдсон : 2019.11.13 02:	5 5	٩	8	MOH '
Улирал	Эхлэх 2019-11-06	☐ → ^Д уусах 2019-11-13	Хайх					
		Харыцсан дансны нар	Валют	Орлого	Sapnara		Үлдэгдэл	
XY!I		МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК	MNT	-	4,000.00		956.10	
ТӨВ БАНК			MNT	-	3,800.00		4,956.10	
Payment :000040086251			MNT	-	300.00		8,756.10	
Wil		МОБИКОМ КОРПОРАЦИ ХХК	MNT	8	4,000.00		9,056.10	

6.3 ХАРИЛЦАХ ДАНС НЭЭХ

Та Харилцах данс үндсэн цэсний "Данс нээх" дэд цэсээр дамжуулан өөрийн нэр дээр шинээр харилцах данс нээх боломжтой.

Харилцах дансны ерөнхий нөхцөлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.golomtbank.com хаягнаас харна уу.

	Харилцагчийн дугаар	Вгловний има <u>ж. хохох</u> Суна выяблядка: 2016 1133 08/31 (Д.) (Z.) (
А нуур	ХАРИЛЦАХ ДАНС	Хлячицахданс • харилцахданснээх
≓ าหนิภเวอ >	Улдэгдэл МNT 140,000.00	O O O
МИНИЙ САНХҮҮ >	Vancana	Хүсалт Баткаларуулах Гарао Дуусах
харилцах данс 🗸	CNY 0.00	Enverse
Үлдэгдэл, хуулга Данс наах Данс хаах	Ридэндал : Сму 0.00	Ундерн Данс Ундерн Данс
Дансны эрхийн тохиргоо	Улдагдал ММТ 10,000.00	MNT Illersystem state
= карт >	Улдэгдэл ММТ 1,067,100.00	Generations visit values 140,000,00 MMT Danse visites generations (2000,00 MMT
• төльөр >	Yngargan : USD 0.00	
 нэмэлтүйлчилгээ ханшийн самбар 	• Улдэгдэл : МИТ 10,163.12	Урганжлуулах

Хүсэлт нүүрэн дээрх мэдээллүүдийг оруулан "Үргэлжлүүлэх" товч дарснаар Баталгаажуулах нүүр гарч ирнэ. Мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулж, Харилцах дансны Гэрээтэй танилцан Батлах нууц үгээ (буюу гүйлгээний нууц үг) оруулснаар таны гүйлгээ хийгдэж Дуусгах нүүр гарч ирнэ.

6.4 ХАРИЛЦАХ ДАНС ХААХ

Хэрэв та өөрийн аль нэг харилцах дансыг хаахыг хүсвэл салбарт очихгүйгээр интернэт банкаараа дамжуулан хаах боломжтой.

Харилцах дансны ерөнхий нөхцлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.golomtbank.com хаягнаас харна уу.

Casin calibrat GALLY	Харилцагчийн дугаар	Өдрийн манд 🍝 ХООХХ. Суунд килбигудсан - 2013 11:10 15:18: 🛆 🖉 МОН 🗸
л нүүр	ХАРИЛЦАХ ДАНС	харилцах данс • харилцах данс хаах
ศัาาพัлгээ >	Улдэгдэл МNT 140,000.00	O O
е миний санхуу >		Хусант Багангабжуулах Дуусгах
🖿 харилцах данс 🗲 🗲	Улдагдэл СNY 0.00	
Үлдэгдэл, хуулга Данс нээх Данс хээх	Улдокдол : СNУ 0.00	Xaargae 🗸
Дансны эрхийн тохиргоо	Ридэхдэл : МNT 10,000.00	
∎ клрт >	Үлдэгдэл	Ашилладагтүй данс 🗸 🗸
š səən >	MNT 1,067,100.00	Урганжлүүлэх
🕈 төлбөр 🗸 🗸	Улдэгдэл	

"Үргэлжлүүлэх" Хүсэлт нүүрэн дээрх мэдээллүүдийг оруулан товч дарснаар Баталгаажуулах нүүр гарч ирэх бөгөөд мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулснаар таны данс хаагдаж Дуусгах нүүр гарч ирнэ.

6.5 EASY INFO БΥΡΤΓΥΥΛЭΧ, СУΗΓΑΧ

Easy Info нь харилцагчийн бүх төрлийн дансны орлого зарлагын гүйлгээний мэдээллийг бүртгэлтэй и-мэйл хаяг болон гар утсанд мессэжээр хүргэх үйлчилгээ юм.

Хэрэв та өмнө нь уг үйлчилгээнд бүртгүүлж байсан бол доорх мэдээлэл харагдана.

G	ОПОМТ БАН Сайх сайхныг санхуунуу	K	Xapı	илцагчийн дугаар	~	۲				энд } эн:201	Шинээр нэмж бурт	тгэл
ń	нүүр	>	XA	РИЛЦАХ ДАНС			EASYINFO DAHCH	Ы ЖАГСААЛТ	Ямар хэлээр мэдэ авч байхаа тохиру	элэл улах	хийх бол "+" товч д дарна уу.	цээр
¢	гүйлгээ	>	Ē	Цалингийн харилцах *** *** 3231	Нийт үлдэгдэл 3,800,000∓	I	Харилцагч таны бүх тө таны Имейл хаяг болоо	рлийн дансны орлого зарлагын гүйлг н гар утсанд мессэжээр хүргэх үйлчи.				
•	МИНЙИ САНХҮҮ ХАРИЛЦАХ ДАНС	> ~		Гүйлгээний тү	γx		Утасны дугаар:	Э-мэйл: Ashiglah@gmail.com	Хал Монгол	· · · ·	хадгалах +	D
				Дансны дэлгэрэн	нгүй		Дансны дугаа	ар Мэдээллэх доод д	үн Дуусах огноо	Холбогдох суваг	- Төлөв	
		roo		Easyinfo				5000 MNT	2019/06/10	Имейл / Мессеж	• Идэвхтэй	
÷		>		Картын харилцах	Нийт үлдэгдэл 400,000₹	:		5000 MNT	2019/06/10	Имейл	• Идэвхгүй	\leftarrow
	карт	>		Энгийн харилцах	Нийт үлдэгдэл 123.0007	:					Сунгах	ר
\$	зээл	>			,						Цуцлах	
•	төлбөр нэмэлт үйлчилгээ	> >										

САНАМЖ

- илгээгдэнэ.
- уу.

> Бүртгэл хийгдсэнээс хойш 2 цагийн дараа үйлчилгээ идэвхжиж мэдээлэл > Easy Info үйлчилгээг цуцалснаар таны төлсөн төлбөр буцах боломжгүйг анхаарна

7. Хадгаламж

7.1 ҮЛДЭГДЭЛ ХУУЛГА

Энд таны нэр дээрх бүх хадгаламжийн дансны жагсаалт харагдах бөгөөд та данс тус бүр дээр дарж дэлгэрэнгүй мэдээллийг харах боломжтой.

Сайс сайсенее салгаровремо	Харилцагчийн дугаар	× ()						Өдрийн мэнд Сүүлд шин-анла Холболт салгаа	а 🚊 XXXXXX ягдсэн : 2019.12.11 18:07 х хугацаа: 29 мин, 49 сек	۵ (۵	мон
\Lambda нүүр	ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛ		🔇 хадгаламж	• ХАДГАЛАМЖИЙН ДАНС	0						
≓ гүйлгээ >	Үңдэсний хуримтлал	БАТЧУЛУУН			2019-09-10	⇒ 2019-12-11	🛱 Хайх				
🗢 миний санхүү 🔶	1,316,246 MNT	1,200,000 MNT	ГҮЙЛГЭЭНИЙ ЖАГС	халт							
🖿 ХАРИЛЦАХ ДАНС 🗲	622 хоног өнгөрсөн	2018-03-30	Гүйлгээний огноо	Гүйлгээний утга		Харьцсан дансны нэр	Валют	Орлого	Зарлага	Үлдэгдэл	
🔅 хадгаламж 🗸 🗸											
Хадгаламжийн данс	Үндэсний хуримтлал	ГАНБАТ ГОЧ	2019-10-29	данс руу ДТхийж хадгаламжийг сунгав [Credit]		-	MNT	28,959	-	571,777	
Хадгаламж нээх	2225544004415-HMI		2019-10-29	Ac xfr from gl 22001 to 22327		-	MNT	542,818	-	542,818	
Хадгаламж хаах	0 MNT	3,600,000 MNT	2019-10-29	Ac xfr from gl 22001 to 22327		-	MNT	-	542,818	0	
Хадгаламж сунгах	69 хоног үлдсэн	2020-02-18	< 1 >								

7.2 ХАДГАЛАМЖ НЭЭХ

Та **Хадгаламж** үндсэн цэсний **"Хадгаламж нээх"** дэд цэсээр дамжуулан өөрийн нэр дээр Хуримтлалын, Хугацаатай болон Хугацаагүй хадгаламжийн данс нээн дурын салбараас хадгаламжийн дэвтрээ үнэгүй аваарай.

Собе собское соссударное	Харилцагчыйн дугаар 🗸 💿			Өдрийн мэнд 🛕 ХХХХХ Сүүнд холбогдсон: 2019.11.20 13:47 (Д) (Д) МОН
нур	ундэсний хуримтлал	хадгаламж • хадгаламж нээх		
≓ำาหัлгээ >	Үндэсний хуримтлал АРИУНЧИМЭГ - MNT		Та хадгаламжийн төрлөө сонгоно уу	
🗢 миний санхүү >	1,810,000.00 MNT 3,600,000.00 MNT			
🗖 ХАРИЛЦАХ ДАНС 🗲 🗲	98 хоног үлдсэн 2020-02-26	Ingloose (Destillation	•	\sim
🗰 хадгаламж 🗸 🗸		хуримтлалын хадгаламж	ЭНГИЙН ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ	хугацаагүй хадгаламж
Хадгаламжийн данс Хадгаламж нээх	Ундасний хуримтлал АДАРСҮРЭН - MNT			
Хадгаламж хаах	1,889,211.07 MNT 1,200,000.00 MNT	10,000₮	10,000₮	10,000₮
Хадгаламж сунгах	429 хоног өнгөрсөн 2018-09-18	доод үндэгдэл	доод мідэгдэл	доод мидагдал
≡ карт >		товч мадзалал	товч мэдээлэл	товч мэдээлэл
💩 зээл 💦 📏	Ундэснии хуримтлал БОЛОРМАА - MNT	Тогтмол хугацаанд хуримлалдаа орлого хийж чадсан бол УРАМШУУЛАГтай. Насан туршдаа	Хуримтлалаа нэмэгдүүлэхийг дэмжих тул орлого авах нохцолтэй.	Орлого, зарлага хийгдэх уян хатан нохцолтэй
төлбөр >	10,324.00 MNT 1,200,000.00 MNT	хурим луулых осноженся.	онцлог	онцлог
🛯 нэмэлтүйлчилгээ >	569 хоног өнгөрсөн 2018-05-01	Онцлог Тогтмол хугацаанд хуоимлалдаа орлого хийж	Хугацааны дундуур банкны хүү өөрчлогдсон эсэхээс үл хамааран хугацаа дуусах хуртэл	Орлого, зарлага хийгдэх уян хатан нохцолтэй
🗃 ханшийн самбар		чадсан бол УРАМШУУЛАЛ-тай. Насан туршдаа хуримтлуулах боломжтой.	гэрээнд заасан хувь хэмжээгээр хадгалуулсан мөнгө, нэмж хийсэн орлогод хүү тооцож олгоно.	ДАВУУ ТАЛ
 АТМ БАЙРШИЛ 	-MNT	давуу тал	давуу тал	Сар сур хүү онгох нокцолтям, зарлага гаргах тоххолдолд, нейт харгаламскейкова хүүг алдахгүй байк Та www.egolomt.mn хаягаар орж
тооцоолуур	10,000.00 MNT 1,500,000.00 MNT	Таныя хуримлтрулах зуршилд сургана. Та www.epolomt.mn хаягаар орж дансаа нээлгэх	Заавал сар бүр орлого жиккийг шаардахгүй тул боломжтой үедээ хадгаламжиндаа орлого	дансаа нээлгэх боломжтой
	2// хоног үлдсэн 2020-08-23	боломоктой.	хийгээд өндөр хүү тооцуулан авна.	Данс нээх
	ЭНГИЙН ХАДГАЛАМЖ	Данс нээх	Данс нээх	
	УРАНГУА ЖА Үлдэгдэл МNT 250,000,000.00			

7.2.1 ХУРИМТЛАЛЫН ХАДГАЛАМЖ НЭЭХ

Хуримтлалын дансыг зөвхөн Төгрөгийн валютаар нээх боломжтой.

Сайт сайлина салару	HK	Харилцагчийн дугаар	~ •	
🗙 нүүр		ҮНДЭСНИЙ ХУРИМТЛАЛ		🔇 хадгаламж • хадгаламж нээх
≓ гүйлгээ	×	Үндэсний хуримтлал	АРИУНЧИМЭГ	
🗳 МИНИЙ САНХҮҮ	>	1,810,000.00 MNT	3,600,000.00 MNT	
🔲 ХАРИЛЦАХ ДАНС	>	105 хоног үлдсэн	2020-02-26	
🔅 хадгаламж	~			
Хадгаламжийн данс		Үндэсний хуримтлал	АДАРСҮРЭН	
Хадгаламж хаах		1,889,211.07 MNT	1,200,000.00 MNT	
Хадгаламж сунгах		422 хоног өнгөрсөн	2018-09-18	Сар бүр төлөх дүн:
🚍 карт	>			Доод үлдэгдэл:
🛎 зээл	>	Үндэсний хуримтлал	БОЛОРМАА	Λαμμ αντακολοτική λην αίμαα.
💿 төлбөр	>	10,324.00 MNT	1,200,000.00 MNT	
нэмэлт үйлчилгээ	>	562 хоног өнгөрсөн	2018-05-01	
ай ханшийн самбар		Шинэ байр	УРАНГУА ЖА	
АТМ БАЙРШИЛ		10,000.00 MNT	1,500,000.00 MNT	
тооцоолуур		284 хоног үлдсэн	2020-08-23	
		ЭНГИЙН ХАДГАЛАМЖ		
			Үлдэгдэл INT 250,000,000.00	
		АЛТАНГАДАС	Үлдэгдэл	

Хуримтлалын зорилго, Сар бүр хийх мөнгөн дүн болон Доод үлдэгдэл шилжүүлэх дансаа сонгон "Үргэлжлүүлэх" товч дээр дарна. Мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулснаар Хуримтлалын хадгаламжийн Гэрээ гарна. Гэрээ нөхцөлтэй танилцан Батлах нууц үгээ (буюу гүйлгээний нууц үг) оруулан "Үргэлжлүүлэх" товч дарснаар таны Хуримтлалын хадгаламжийн данс амжилттай үүснэ.

			Үдшийн мэнд 🍐 XXXXX Сүүлд холбогдсон : 2019.11.13 03:33 🙆 🤇	мон \
УРИМТЛАЛЫН ХАДГАЛАМЖ				
	0			
	Баталгаажуулах	Дуусгах		
үндэсний				
ХУРИМТЛАЛЫН жгозор		Доод үлдэгдэл шилжүүлэх данс:		
Somethin		Сонгох	Боломжит үлдэгд	00.0 :ne
	20,000.00 MNT 10,000.00 MNT			
	1 жил			
	БУЦАХ	үргэлжлүүлэх		
				G

7.2.2 ХУГАЦААГҮЙ ХАДГАЛАМЖ НЭЭХ

Хугацаагүй хадгаламжийн дансыг Төгрөг болон Ам.долларын валютаар нээх боломжтой.



Хүсэлт нүүрэн дээрх мэдээллүүдийг оруулан "Үргэлжлүүлэх" товч дарснаар **Баталгаажуулах** нүүр гарч ирнэ. Мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулснаар Хугацаагүй хадгаламжийн **Гэрээ** гарна.

	Хусалт	Баталгаажуулах	Гэрээ	Дуусгах
19				
 Нэг талаас Голомт банк (цаашид " мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо 	банк" гэх) нөгөө талаас инте , зээлийн үйл ажиллагааны т	рнэт банкаар үйлчилгээ авч буй харилца гүхай хүүль"–ийг үндэслэн дараах гол нө	агч (цаашид "хадгалуулагч" гэх) н хцлүүдийг харилцан тохиролцож	ь Монгол Улсын "Иргэний хууль", "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээ байгуулав.
2. Хадгалуулагч нь банкны нийтэд за	рласан бүтээгдэхүүний нөхц	алтэй танилцан хүлээн зөвшөөрч энэхүү	гэрээг байгуулсан болно.	
3. Хадгаламжийн нэг өдрийн хүүг то	эцохдоо жилийн хүүг 365 хо	ногт хувааж, нийт хүүг тооцохдоо хадгал	пуулсан хоногоор үржүүлнэ.	
4. Хугацаагүй мөнгөн хадгаламжид б	іэлэн болон бэлэн бусаар ор	лого, зарлагын гүйлгээг хэдийд ч хийх б	оломжтой.	
 Хадгаламжийн хүүг сар бүрийн эц олгоно. 	сийн өдрөөр тооцож тухайн	хадгаламжийн дансанд олгоно. Хэрэв х	адгалуулагч дансаа сарын дунду	р хааж буй тохиолдолд данс хааж байгаа өдөр хүртэл хүүг бодож
Банк тогтоосон хүүгийн хэмжээгэ:	еврчлех тохиолдолд нийтэ;	д мэдээлсэнээс хойш нэг сарын дараа х	үүг өөрчлөгдсөн хэмжээгээр тоо	цно.
7. Хадгалуулагч нь гэрээний хугацаа	нд орлого, зарлагын гүйлгээ	хийж болох бөгөөд гүйлгээ, үлдэгдлийг	мөнгөн хадгаламжийн дэвтрийн	гүйлгээтэй тулган шалгаж байна.
 хадгалуулагч нь "иргэний хууль"- пин код гэдэг нь хадгалуулагч бан сорилах хисэдт тавьж больо. 	ийн дагуу өөрийн мөнгөн ха, кин дахь мөнгөн хадгаламжа	дгаламжииг хамтран эзэмших, өвлүүлэх аа захиран зарцуулахад баталгаат гарын	, гэрээслэх, оэлэглэх, шилжүүлээ үсгийн хамт хэрэглэх, гүйлгээ хи	, иттэмжлэл гаргах, электрон гарын үстийг (Электрон гарын үсэг оую йснийг зөвшөөрч баталгаажуулсныг давхар нотлох тоон тэмдэгт юм.)
 Уг хадгаламжийн дансыг үндсэн э. 	зэмшигч болон хамтран эзэн	мшигч аль аль нь банкны интернэт банкн	ы үйлчилгээ ашиглан эсвэл дуры	н салбар дээр очиж сунгах, цуцлах, хаах эрхтэй.
10. Салбарт ирж зарлагын гүйлгээ хий	іхдээ мөнгөн хадгаламжийн	і дэвтэр, иргэний цахим үнэмлэхээ заава	ил авч ирэх бөгөөд интернэт банк	аар гүйлгээ хийхдээ электрон гарын үсгээ мэдэж байх үүрэгтэй.
 Банк нь гэрээг Хадгалуулагчийн ху заасан эрхийнхээ дагуу мөнгөн ха, 	салтаар түүнтэй байгуулсан дгаламжаа захиран зарцуул	н бөгөөд мөнгөн хадгаламжийн хууль ёсн кнаас гуравдагч этгээдэд учирсан хохир	ны эзэмшигч болох гуравдагч этг элыг Банк хариуцахгүй.	ээд байгаа эсэхийг Банк мэдэх боломжгүй тул Хадгалуулагч гэрээнд
 Дээрх нехцелийг зөвшөөрсөн нь х тооцно. 	арилцагчийн интернэт банкн	ны гүйлгээний нууц үгээр /И-токен/ бата	лгаажигдах бөгөөд гүйлгээний н	уц үгийг /И-токен/ баталгаат гарын үсэг зурсантай адил хүчинтэйд
_				
Ð	Энэхүү хадгаламжийн бү	тээгдэхүүний нөхцөл, онлайн хадгал	памжийн үйлчилгээний гэрээ	гэй танилцаж зөвшөөрсөн болно
	🔒 Батла	их нууц үг		мартсан?

Гэрээ нөхцөлтэй танилцан Батлах нууц үгээ (буюу гүйлгээний нууц үг) оруулан "Үргэлжлүүлэх" товч дарснаар таны нэр дээр автоматаар Хугацаагүй хадгаламжийн данс нээгдэж **Дуусгах** нүүр гарч ирнэ.

7.2.3 ХУГАЦААТАЙ ХАДГАЛАМЖ НЭЭХ

Хугацаатай хадгаламжийн дансыг зөвхөн Төгрөгийн валютаар нээх боломжтой.

🖨 нүүр	үндэсний хуримтлал		0	ХАДГАЛАМЖ • ХАДГАЛАМЖНЭЭХ • ЭН
🗗 гүйлгээ	Үндэсний хуримтлал - MNT	АРИУНЧИМ	юг	
🗢 МИНИЙ САНХҮҮ	1,810,000.00 MNT	3,600,000.00 MI	NT	
🔲 ХАРИЛЦАХ ДАНС	98 хоног үлдсэн	2020-02	-26	
🖡 хадгаламж				
Хадгаламжийн данс	Үндэсний хуримтлал	АДАРСҮР	эн	Хадгаламжийн төрөл
Хадгаламж нээх Хадгаламж хаах	Данс нээх д	100д үлдэ	гдэл	Хадгаламжийн хугацаа сонгох
Хадгаламж сунгах	автоматаар	харагдах	<	Сонгох
карт	бөгөөд уг д нээхийг хүс	үнгээс их вэл гараа	ээр ар	Данс нээх дүн Данс нээх доод дүн 0.00
зээл	бичиж өөрч	лөх боло	жтой	Шилжүүлэгч данс сонгох Uuugii (MNT)
төлбөр	Ļ			
нэмэлт үйлчилгээ	569 хоног өнгөрсөн	2018-05	-01	
ХАНШИЙН САМБАР	Шинэ байр	УРАНГУА 3	жа	
АТМ БАЙРШИЛ	10,000.00 MNT	1,500,000.00 M	NT	
тооцоолуур	277 хоног үлдсэн	2020-08	-23	
	ЭНГИЙН ХАДГАЛАМЖ			
	🛊 УРАНГУА ЖА	Үлдэгдэл МNT 250,000,000.00	1	

Хүсэлт нүүрэн дээрх мэдээллүүдийг оруулан "Үргэлжлүүлэх" товч дарснаар **Баталгаажуулах** нүүр гарч ирнэ. Мэдээллийг зөв оруулсан эсэхээ шалган баталгаажуулснаар Хугацаатай хадгаламжийн **Гэрээ** гарна.

